



## НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН САРЫН МЭДЭЭНИЙ ТОЙМ

2022 оны  
09-р сар

Нийгмийн даатгалын санд 2022 оны 09 дүгээр сарын 30-ны байдлаар нийт 1 299.83 тэрбум төгрөгийн шимтгэлийн орлого төвлөрүүлж, орлогын төлөвлөгөөг 109.38 хувиар биелүүлсэн байна. Давхардсан тоогоор 321431 иргэний тэтгэвэр, тэтгэмж, төлбөрийн зардалд нийт 1 119.07 тэрбум төгрөг зарцуулжээ.

### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ОРЛОГО

Нийгмийн даатгалын санд энэ оны 09 дүгээр сард 1 299.8 тэрбум төгрөгийн сангийн орлого төвлөрүүлсэн нь өмнөх оны мөн үетэй харьцуулахад 344.2 тэрбум төгрөгөөр өссөн байна.

Ажил олгогч, даатгуулагчаас төлсөн шимтгэлийн орлогыг дараах байдлаар нийгмийн даатгалын сангуудад хуваарилсан байна. Үүнд :

- Тэтгэврийн даатгалын санд 82.38% буюу 1066.45 тэрбум төгрөг;
- Тэтгэмжийн даатгалын санд 8.54% буюу 110.55 тэрбум төгрөг;
- ҮОМШӨ-ний даатгалын санд 7.18% буюу 92.96 тэрбум төгрөг;
- Ажилгүйдлийн даатгалын санд 1.89% буюу 24.52 тэрбум төгрөг;


### НИЙГМИЙН ДААТГАЛЫН САНГИЙН ЗАРЛАГА

2022 оны 09 дүгээр сард нийгмийн даатгалын сангаас тэтгэвэр, тэтгэмж, төлбөр, тусламж, үйлчилгээний зардалд нийт 879.1 тэрбум төгрөг зарцуулжээ. Өмнөх оны мөн үетэй харьцуулахад сангийн зардал 53.6 тэрбум төгрөгөөр өссөн байна.


### Тэтгэврийн даатгалын сан

Тухайн сард тэтгэврийн даатгалын санд 1089.27 тэрбум төгрөгийн орлогыг төвлөрүүлж, Тус сангаас өндөр насны, тахир дутуугийн, тэжээгчээ алдсаны, цэргийн тэтгэвэр авагч 196795 иргэдийн тэтгэвэрт 997.0 тэрбум төгрөг зарцуулжээ. Нийт 78.3 хувь буюу 780.54 тэрбум төгрөгийг өндөр насны тэтгэвэр авагч 151995 иргэнд зарцуулсан байна.


### Нийгмийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/



### Нийгмийн даатгалын сангийн зарлага /тэрбум төгрөгөөр/



### Тэтгэврийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/



### Тэтгэмжийн даатгалын сан

Энэ оны 09 дүгээр сард тэтгэмжийн даатгалын сангаас хөдөлмөрийн чадвар түр алдсаны, жирэмсний болон амаржсаны, оршуулгын тэтгэмж авсан 107322 иргэнд 73.07 тэрбум төгрөг зарцуулсан байна. Нийт тэтгэмжид зарцуулсан хөрөнгийн 54.3 тэрбум төгрөг буюу 74.4 хувийг жирэмсний болон амаржсаны тэтгэмж эзэлж байна.

### Үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалсан өвчний даатгалын сан

Тус сангаас 09 дүгээр сард тахир дутуугийн болон тэжээгчээ алдсаны тэтгэвэр авагчдын, хөдөлмөрийн чадвар түр алдсаны тэтгэмж, хөдөлмөрийн чадвар нөхөн сэргээхтэй холбогдсон төлбөр, рашаан сувилалд ирж, буцах болон сувиллын зардал, үйлдвэрлэлийн осол, мэргэжлээс шалтгаалах өвчнөөс урьдчилан сэргийлэх арга хэмжээний зардалд нийт 2879 иргэнд 11.6 тэрбум төгрөгийг зарцуулав.


### Ажилгүйдлийн даатгалын сан

Ажилгүйдлийн даатгалын санд 09 дүгээр сард 8.1 тэрбум төгрөгийн орлого төвлөрүүлэн, 12747 хүний ажилгүйдлийн даатгалын тэтгэмжид 27.2 тэрбум төгрөгийг зарцуулсан. Сангийн орлого өмнөх оны мөн үетэй харьцуулахад 4.0 тэрбум төгрөгөөр буурч, зарлага 643.7 сая төгрөгөөр өссөн байна.

### Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага

202 оны 09 дүгээр сарын байдлаар нийгмийн даатгалын шимтгэлийн авлага 323.6 тэрбум төгрөг байна. Нийт шимтгэлийн авлагын 98.2 хувь буюу 318.2 тэрбум төгрөгийг аж ахуйн нэгж байгууллагуудын авлага эзэлж байна. Мөн авлагын 55.9 хувийг 121 ба түүнээс дээш хоногтой хуримтлагдсан авлагын дүн эзэлж байна.


### Тэтгэмжийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/




### ҮОМШӨ-ний даатгалын сангийн зарлага /сая төг, өссөн дүнгээр/

	2021_09 сар	2022_09 сар	Зөрүү
Тахир дутуугийн	8 476.8	9 642.1	1 165.3
Тэжээгчээ алдсаны	916.1	1 100.5	184.4
Тэтгэмж. төлбөрийн	298.0	592.6	294.6
Сувиллын	26.9	239.6	212.7
<b>Нийт дүн</b>	<b>9 717.8</b>	<b>11 574.8</b>	<b>1857.0</b>

### Ажилгүйдлийн даатгалын сангийн орлого, зарлага /тэрбум төгрөгөөр/



### Нийгмийн даатгалын шимтгэлийн авлага /сая төгрөгөөр/



**Нийгмийн даатгалын байгууллагын үйл  
ажиллагааны зардал**

Нийгмийн даатгалын байгууллагын үйл ажиллагааны зардалд 9 сарын мэдээгээр нийт 6 479.65 сая төгрөг төлөвлөснөөс 5 876.50 сая төгрөг зарцуулж, 603.15 сая төгрөг хэмнэсэн байна. Батлагдсан орон тоо 433 байгаагаас 431 орон тоогоор ажилласан.

**Үйл ажиллагааны зардал /сая төгрөгөөр/**

	2021_9 сар	2022_9 сар	Өөрчлөлт	
			Дүн	Хувь
Цалингийн сан. нийгмийн даатгалын шимтгэл	4 219.25	4 707.02	487.77	11.5%
Бараа үйлчилгээний бусад зардал	1 377.17	1 079.48	-297.69	21.6%
<b>Дүн</b>	<b>5 596.42</b>	<b>5 786.50</b>	<b>190.08</b>	<b>3.4%</b>